


ADB

СТРАТЕГИ 2030

ЦЭЦЭГЛЭН ХӨГЖСӨН
ХҮРТЭЭМЖТЭЙ
ТЭСВЭРТЭЙ
ТОГТВОРТОЙ

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ



АХБ яагаад стратегиа шинэчлэв?

Ази, Номхон далайн бүс нутаг ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжлийг цогцлоох тал дээр өнгөрөгч тавин жилд гайхалтай амжилт гаргасан хэдий ч биелүүлж дуусгах шаардлагатай хөгжлийн зорилтууд байсаар байна. 2030 он хүртэлх стратеги нь бүс нутгийн хувьсан өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээг хангах АХБ-ны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.

ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ОРЧИН

Эдийн засгийн таталцлын төвийн шилжилт



Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутаг хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж байна.

Дэд бүтцийн үлэмж их хэрэгцээ шаардлага

Бүс нутагт дэд бүтцийн хомсдолыг арилгахын тулд 2016-2030 онд **жил бүр 1.7 их наяд ам.долларын**



дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Шийдэгдээгүй үлдсэн ядуурал ба тэгш бус байдлын асуудлууд


Бүс нутагт амьдарч буй **3 хүний 1 нь**



буюу нийт **1.24 тэрбум хүн** өдрийн 3.20 ам.доллараас бага орлогоор амьдарч байна.


Хурдацтай хотжилт

Ази, Номхон далайн бүс дэх хот суурин газар амьдарч буй хүн амын хувь хэмжээ нэмэгдсээр.




Технологийн хөгжил

бүтээмжийг өсгөх ч, цаашдын ажлын байранд нөлөөлнө.



Залуучууд ба өндөр настнууд

Зарим орны хүн ам хурдан хөгширч байна. Бүс нутгийн өндөр настнуудын хувь хэмжээ өсөх хандлагатай.



Бусад орнууд нь залуу хүн амтай. Энэ нь боломж ба сорилтын аль алиныг бий болгоно.

30-аас доош насны залуусын 54%



Ази, Номхон далайн бүсэд амьдардаг.

Уур амьсгалын өөрчлөлт, орчны доройтол ба байгалийн гамшиг



Дэлхийн хамгийн өндөр гамшгийн эрсдэлтэй **10 орны 7 нь** АХБ-ны хөгжиж буй гишүүн орон байна. (Бангладеш, Камбож, Филиппин, Соломон Арал, Зүүн Тимор, Тонга, Вануату).

АХБ-НЫ 2030 ОН ХҮРТЭЛХ ХЭТИЙН ЗОРИЛГО ЮУ ВЭ?

Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөнд тэсвэртэй бүс нутгийг цогцлоох нь АХБ-ны хэтийн зорилго юм.

**ЦЭЦЭГЛЭН ХӨГЖСӨН
ХҮРТЭЭМЖТЭЙ
ТЭСВЭРТЭЙ
ТОГТВОРТОЙ**

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ



АХБ нь бүс нутаг дахь нэн ядуу, эмзэг улс орнуудад тэргүүлэх ач холбогдол өгсөн хэвээр байх болно.

АХБ дэд бүтцийн салбарт тэргүүлэх ач холбогдол өгч ажиллахын зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар дахь үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.

АХБ ҮНЭ ЦЭНИЙГ ХЭРХЭН БҮТЭЭХ ВЭ?

АХБ дараах байдлаар үнэ цэнийг бүтээнэ:



САНХҮҮ

Санхүүжилтийг өөрийн эх үүсвэрээс олгоод зогсохгүй бусад эх үүсвэрээс татан төвлөрүүлнэ.



МЭДЛЭГ

Орон нутгийн онцлогт тохирсон бодит үнэ цэнийг бүтээхэд анхаарлаа хандуулж, сургамжаа тодорхойлон, шилдэг туршлагаудаа нэвтрүүлнэ.



ТҮНШЛЭЛ

Олон талт түнш, оролцогчдын хоорондын нягт харилцаа, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

АХБ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯМАР ЗАРЧМААР ЯВАГДАХ ВЭ?

УЛС ОРНЫ ОНЦЛОГТ ТОХИРСОН АРГАЧЛАЛЫГ АШИГЛАХ

Хөгжиж буй гишүүн орон (ХБГО) бүрийн хөгжлийн хэрэгцээ, сорилтуудад тохирсон шийдлүүдийг санал болгоно.

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

Үйл ажиллагаандаа дэвшилтэт технологийг хэрэглэх арга замыг санаачлагатайгаар эрэлхийлж, ХБГО-ууддаа чадавхи бэхжүүлэх дэмжлэг үзүүлнэ.

ЦОГЦ ШИЙДЭЛ ГАРГАХ

Төр ба хувийн хэвшлийн үйл ажиллагааг хослуулах замаар олон салбар, чиглэлийн мэдлэг туршлагыг нэгтгэнэ.

АХБ ХАРИЛЦАГЧДЫНХАА ХАРИЛЦАН АДИЛГҮЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХЭРХЭН ХАНГАХ ВЭ?

АХБ нь улс орнуудын ангилалд тохирсон аргачлалуудыг ашиглана.



Эмзэг ба мөргөлдөөнд өртсөн орнууд

- институцийн хөгжил ба засаглалын шинэчлэл
- суурь дэд бүтэц ба нийгмийн үйлчилгээ
- зорилтот нийгмийн хамгаалал
- сөрөг нөлөөнд тэсвэртэй байдлыг бий болгох, зөрчил мөргөлдөөний шалтгааныг шийдвэрлэх, эвлэрэл ба сэргээн босголтыг эрчимжүүлэх



Жижиг арлын хөгжиж буй улсууд

- уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицол, байгаль орчны тогтвортой байдал, гамшгийн эрсдэлийн менежмент
- хүртээмж ба харилцаа холбоо
- тогтолцооны бэхжүүлэлт
- бизнесийн орчныг сайжруулах, хувийн хэвшил манлайлсан өсөлтийг дэмжих хүчин чармайлт



Бага ба бага-дунд орлоготой орнууд

- ногоон бөгөөд хүртээмжтэй дэд бүтэц
- нийгмийн үйлчилгээ ба хамгаалал
- тогтвортой хотжилт
- бүтцийн өөрчлөн сайжруулалт ба төрийн салбарын шинэчлэл
- хувийн хэвшлийн хөгжил ба дотоодын хөрөнгийн ашиглалт



Дээд-дунд орлоготой орнууд

- хөрөнгийн зах зээлд холбох
- тогтолцоог бэхжүүлэх, загвар төсөл хэрэгжүүлэх
- хувийн салбарын үйл ажиллагаа
- бүсийн сайн сайхны төлөө ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграци, хүн амын хөгшрөлт

Эдгээр бүх бүлэг улсуудын хөгжлөөс хоцрогдсон хэсгүүд болон ядуу, эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэхэд АХБ нэн тэргүүнд анхаарна.

АХБ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯМАР ЧИГЛЭЛҮҮДЭД ТӨВЛӨРӨХ ВЭ?

АХБ дараах 7 тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.



Ядуурлын асуудлыг бүрэн шийдвэрлэх ба тэгш бус байдлыг бууруулах

хүний хөгжил ба нийгмийн оролцоо, чанартай ажлын байр, боловсрол ба сургалт, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал



Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, уур амьсгал, гамшгийн эрсдэлийг даван туулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах

хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг даван туулах чадавх бий болгох арга хэмжээ, байгаль орчны тогтвортой байдал, “ус-хүнс-эрчим хүч”-ний аюулгүй байдлын гурвалсан холбоо



Хөдөөгийн хөгжил, хүнсний аюулгүй байдлыг дэмжих

зах зээлд гарах гарц, хөдөө аж ахуйн үнэ цэнийн сүлжээ, хөдөө аж ахуйн бүтээмж ба хоол тэжээлийн баталгаат байдал, хүнсний аюулгүй байдал



Бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцчиллыг хөхиүлэн дэмжих

харилцаа холбоо ба өрсөлдөх чадвар, бүс нутгийн сайн сайхны төлөө ажиллагаа, санхүүгийн салбарын хамтын ажиллагаа, дэд бүсийн санаачлагууд



Жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг эрчимжүүлэх

Жендэрийн тэгш байдлыг дэмжих ажлыг эрчимжүүлэх, эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг бэхжүүлэх, хүний хөгжилд жендэрийн тэгш байдлыг хангах, манлайлал, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн цагийн ачааллыг багасгах, эмэгтэйчүүдийн сөрөг нөлөөг даван туулах чадавхыг бэхжүүлэх



Хот суурин газрын амьдрах орчинг сайжруулах

цогц шийдлүүд, хот суурин газрын санхүүжилт, оролцоог хангасан, хүртээмжтэй хот төлөвлөлт, уур амьсгалын сөрөг нөлөөллийг даван туулах чадвар, гамшгийн удирдлага



Засаглалыг сайжруулж, тогтолцооны чадавхийг бэхжүүлэх

төрийн удирдлагын шинэчлэл, санхүүгийн тогтвортой байдал, үйлчилгээний чанар ба хүртээмж, чадавх ба стандарт

ЗАРИМ ЗОРИЛТУУД . . .



2030 он гэхэд АХБ-наас баталгаажсан үйл ажиллагааны **75-аас доошгүй** (засгийн газар болон засгийн газрын бус төсөл хөтөлбөрүүдийн 3 жилийн дунджаар) хувь нь жендэрийн тэгш байдлыг дэмжих болно.



2030 он гэхэд санхүүжилт нь баталгаажсан үйл ажиллагааныхаа (засгийн газрын болон засгийн газрын бус дэмжлэгийг оролцуулсан 3 жилийн гулсах дунджаар) **75-аас доошгүй** хувийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн төслүүд байлгахыг зорино. **2019-2030 онд** уур амьсгалын чиглэлээр АХБ-ны өөрийн эх үүсвэрээс олгох санхүүжилтийг өссөн дүнгээр **80 тэрбум ам.долларт** хүргэнэ.

Үүний зэрэгцээ, АХБ дараах чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулна.



ХУВИЙН ХЭВШЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

- хувийн хэвшлийн үйл ажиллагааны гол зорилт нь хөгжлийн үр нөлөө байх
- ашигтай ажиллагаа, арилжааны тогтвортой байдлыг хангах
- шинэ, чадвар сорьсон зах зээлүүд дэх үйл ажиллагаагаа өргөжүүлэх, төрөлжүүлэх



САНХҮҮГИЙН НӨӨЦИЙГ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ

- олон талт, хоёр талт болон хувийн хэвшлийн түншүүдтэйгээ хамтын ажиллагаагаа бэхжүүлэх
- арилжааны болон хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлэх
- төр-хувийн хэвшлийн түншлэлийг ашиглах, ХБГО дахь бизнесийн орчныг сайжруулах, ХБГО-уудын дотоодын нөөц бололцоог ашиглах



МЭДЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

- АХБ-ны мэдлэг түгээх чиг үүргийг бэхжүүлэх
- хамгийн тохиромжтой мэдлэгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэх зорилгоор ХБГО-уудтай нягт хамтран ажиллах
- судалгаа шинжилгээг идэвхжүүлэн, өндөр чанартай бодлогын зөвлөгөө өгч, ХБГО-уудын институцийн чадавхийг бэхжүүлэх
- мэдлэгийн бүтээгдэхүүн ба үйлчилгээг бий болгох, мэдлэг солилцох ажиллагааг байгууллагын болон бүс нутгийн хэмжээнд дэмжих

**ЗАРИМ
ЗОРИЛТУУД . . .**



АХБ-ны хувийн хэвшлийн үйл ажиллагаа нь **2024 он гэхэд нийт үйл ажиллагааны гуравны нэгийг бүрдүүлнэ.**

АХБ ХЭРХЭН ИЛҮҮ ХҮЧТЭЙ, ЧАДВАРТАЙ, ХУРДТАЙ БОЛОХ ВЭ?

Илүү хүчтэй, чадвартай, хурдтай болохын тулд АХБ:

- Хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээ бэхжүүлнэ
- Хүний нөөцөө сайжруулна
- Төлөөлөгчийн газруудаараа дамжуулан улс орнуудад хүрч ажиллах төлөөллөө бэхжүүлнэ
- Бүтээгдэхүүн ба хэрэгслээ сайжруулна
- Бизнесийн үйл явцыг шинэчилж, үйл ажиллагааны үр дүнг сайжруулна
- Цахим хувьсал өөрчлөлтийг дэмжинэ
- Худалдан авалтыг түргэн шуурхай, үнэ цэнэтэй болгоно
- Улс орны дотоод тогтолцоог түлхүү ашиглана
- Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ

2030 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ



2030 он хүртэлх стратегия АХБ дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- 7 тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна
- улс орны түвшний тэргүүлэх чиглэлүүдийг тухайн улс орны түншлэлийн стратегиар илүү нарийвчлан тодорхойлно
- ажлын хөтөлбөр, төсөв бэлтгэх үйл явцыг бэхжүүлж, жилийн төлөвлөгөө болон нөөцийн хуваарилалтыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулна
- байгууллагын үр дүнгийн хүрээг шинээр боловсруулна
- үр дүнгийн хүрээнд түшиглэн байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн тайлангаа үргэлжлүүлэн гаргана



АХБ нь “Нэгдмэл АХБ” аргачлалыг нэвтрүүлж, 2030 он хүртэлх стратегийн төлөвлөгөөгөө үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс банк даяарх мэдлэг туршлагаа нэгтгэн ажиллах болно.

Баримт бичгийг бүтнээр татаж авах хаяг: www.adb.org/strategy2030



АХБ нь **2030 он гэхэд хамтын санхүүжилтээ үлэмж нэмэгдүүлж**, хувийн хэвшлийн санхүүжилтийн 1 ам.доллар тутамд урт хугацаат хамтын санхүүжилтийн 2.50 ам.долларыг татан төвлөрүүлнэ

Стратеги 2030

Цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тэсвэртэй, тогтвортой Ази, Номхон далайн бүсийг цогцлоох нь

Ази, Номхон далайн бүс нутаг ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих тал дээр сүүлийн 50 жилийн хугацаанд ихээхэн ахиц дэвшил гаргасан. Азийн хөгжлийн банк (АХБ) нь бүс нутгийн энэхүү хувьсан өөрчлөлтийн үед гол түншлэгч байсаар ирсэн бөгөөд цаашид ч бүс нутгийг хөгжлийн дараагийн үе шатандаа гарахад нь хамтран ажиллахад бэлэн байна. 2030 он хүртэлх стратеги нь бүс нутгийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад илүү үр дүнтэй нийцэн ажиллах АХБ-ны арга замыг тодорхойлсон баримт бичиг юм. АХБ 2030 он хүртэлх стратегийнхээ хүрээнд Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөг даван туулах чадвартай бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажиллана.

Азийн хөгжлийн банкны тухайд

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөг даван туулах чадвартай бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажиллаж байна. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 67 гишүүн орны 48 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг туслалцаа үзүүлж байна.